



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ДҮГНЭЛТ: Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, хүн ам цөөн, алслагдмал орон нутгийн онцлогийг харгалзан санхүүжилт, төлбөрийн хэмжээг тогтоосноор иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахаар байна.

АУДИТЫН СЭДЭВ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ГНАГ-2023/19-ШТА-ГА

**2023 он
Алтай хот**

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	
Дарга, тэргүүлэх аудитор:	ТУШААЛ	3
Х.Түвшинбаяр	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
Аудитын менежер:	ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ	5
Д.Эрдэнэчимэг	ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	5
Ахлах аудитор:	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	6
Б.Цэвэлмаа	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	6
Аудитор:	Аудитын зорилт	6
М.Атарцэцэг	Аудитын арга зүй	6
С.Санчирмаа	Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	6
Н.Гэрэлмаа	Аудитын хийсэн багийн бүрэлдэхүүн	7
М.Дөлгөөнбаяр	Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл	7
	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	8
	I БҮЛЭГ. Эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, салбарын хөгжлийн зорилтуудтай нийцэж байгаа боловч үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.	9
2023 оны 5 дугаар сар	II БҮЛЭГ. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, санхүүжилтийг хянах журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.	13
Уг тайланг ҮАГ-ын	III БҮЛЭГ. Цахим системийг эрүүл мэндийн даатгалын чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоотой нийцүүлснээр дэвшил гарахаар байна.	19
Цахим хуудаснаас үзнэ	IV БҮЛЭГ. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутмаг, сумдын чанарын албаны үйл ажиллагаа жигдрээгүй байна.	22
ҮҮ:	ДҮГНЭЛТ	23
www.audit.mn	ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР	27
www.open.audit.mn	ХАВСРАЛТ	29
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7048-3413 7048-4030 дугаарын утсаар харилцана уу.	Хавсралт №1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа	29
	Хавсралт №2 Шимтгэлийн өөрөө хариуцан төлөх иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/	31
	Хавсралт №3 Сонгон шалгаруулалтын тусгай шаардлагад нийцэхгүй байгаа ЭМТ-ийн жагсаалт /тусламж үйлчилгээний төрлөөр/	32
	Хавсралт №4 ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан боловч санхүүжилтийг нэхэмжлээгүй тусламж үйлчилгээний үзүүлэлт /мян.төг/	36
	Хавсралт №5 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт аваагүй хасагдсан тусламж үйлчилгээний жагсаалт /Ажилтны хариуцлагатай холбоотой/ /мян.төг/	36
	Хавсралт №6 Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин	38
ХАЯГ:		
Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар		
Есөнбулаг сум, Жинст баг, Хөгжил хороолол, 14-02		

ТУШААЛ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр


Дугаар А/14

Есөнбулаг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралаар баталсугай.
3. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэгт хүргүүлсүгэй.
4. Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг), ахлах аудитор (Б.Цэвэлмаа)-т үүрэг болгосугай.



Х.ТҮВШИНБАЯР

. 07010034

1

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2023 оны 05 дугаар сарын 19 -ны
өдрийн 1/14 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

д/д	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн /сая төгрөг/
1.	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Г.Лхагважаргал	Албан шаардлага өгөх	01/256	0
2.	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Г.Лхагважаргал	Албан шаардлага өгөх	02/256	309.3
3.	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Г.Лхагважаргал	Албан шаардлага өгөх	03/256	82.4
4.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Сэлэнгэ	Албан шаардлага өгөх	04/256	0.6
5.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Сэлэнгэ	Албан шаардлага өгөх	05/256	0
6.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.Сэлэнгэ	Төлбөрийн акт тогтоох	01/168	11.1
7.	Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Энхцэцэг	Төлбөрийн акт тогтоох	02/168	2.5
	Нийт дүн			405.9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

№	Товчилсон үг	Товчилсон үгийн тайлал
1	АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
2	АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
3	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
4	ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
5	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
6	МХГ	Мэргэжлийн хяналтын газар
7	НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
8	ӨСТЭМТ	Өрх, сумын эрүүл мэндийн төв
9	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
10	УАУНЭ	Уламжлалт анагаах нэгдсэн эмнэлэг
11	УИХ	Улсын Их Хурал
12	ҮАГ	Үндэсний аудитын газар
13	ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
14	ЭМД	Эрүүл мэндийн даатгал
15	ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
16	ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
17	ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
18	ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
19	ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Дугаар	Нэр
1	Хүснэгт №1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан байгууллагууд
2	Хүснэгт №2	Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн тооцоо
3	Хүснэгт №3	Хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин
4	Хүснэгт №4	Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн хяналт -2021 он
5	Хүснэгт №5	Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн хяналт -2022 он
6	Хүснэгт №6	№6 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тусламж үйлчилгээний санхүүжилт
7	Хүснэгт №7	Эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамж

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Дугаар	Нэр
1	Хавсралт №1	Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа
2	Хавсралт №2	Шимтгэлийн өөрөө хариуцан төлөх иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
3	Хавсралт №3	Сонгон шалгаруулалтын тусгай шаардлагад нийцэхгүй байгаа байгууллагуудын жагсаалт
4	Хавсралт №4	ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан боловч санхүүжилтийг нэхэмжлээгүй тусламж үйлчилгээний үзүүлэлт
5	Хавсралт №5	ЭМДС-аас санхүүжилт аваагүй хасагдсан тусламж үйлчилгээний жагсаалт
6	Хавсралт №6	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1¹ дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-3200 стандартад нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэлээ.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль (2011 он)
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он)
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016 он)
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2016 он)
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол)
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл

¹6.3.1.шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

ажиллагаа, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)

- Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020-2023 оны тогтоолууд;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020-2023 оны тушаалууд;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017
- Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013
- Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5292:2017
- Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015
- Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актууд

Аудит хийсэн хугацаа

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газраас аудитын урьдчилсан судалгааны үе шатны ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс тус тус эхлэн, аудитын төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн дотор батлуулж аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь аудитын талбарын үе шатны ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс эхлүүлж, аудитын тайлан, шийдвэрийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар болон холбогдох газар, албан тушаалтанд хүргүүллээ.

Аудитын хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэвэлмаа, аудитор М.Атарцэцэг, С.Санчирмаа, Н.Гэрэлмаа, М.Дөлгөөнбаяр нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Гүйцэтгэлийн аудитын төлөвлөсөн хугацаа санхүүгийн тайлангийн аудитын хуулийн хугацаатай давхацсан.

Эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжлэлийн цахим программаас нэгтгэлийн дүн, тайлан татагддаггүй нь дүн шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулахад цаг хугацаа шаардсан.

Мөн оношийн хамааралтай бүлэг, өвчний олон улсын ангилал зэргийг тулган баталгаажуулахад нарийн мэргэжлийн мэдлэг дутагдаж байсан нь хүндрэлтэй байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна. Улмаар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санг нэгтгэн нэг худалдан авагчийн тогтолцоог бий болгож, стратегийн худалдан авалтыг эхлүүлжээ.

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олон улсын эмнэл зүйн удирдамжид үндэслэн оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэх эмчилгээ, үйлчилгээний тарифыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 3 болон 4 дүгээр тогтоолоор баталсан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 4² дүгээр зүйлд зааснаар эмнэлгийн тусламж үйлчилгээ дараах 7 төрөлтэй байна.

- Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ
- Эх барихын тусламж, үйлчилгээ
- Яаралтай тусламж, үйлчилгээ
- Түргэн тусламжийн үйлчилгээ
- Сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээ
- Сэргээн засах тусламж, үйлчилгээ

ЭМДЕГ-тай 2021, 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр лавлагаа шатлалын 5 эмнэлэг, анхан шатны буюу сум, өрх, тосгоны 22 эрүүл мэндийн төв, 32 эмийн сан, 3 сувиллал гэрээ байгуулж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан байна. Хөнгөлөлттэй эмээр үйлчлэхээр 2021 онд гэрээ байгуулсан 3 эмийн сан татан буугджээ.

Хүснэгт №1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан байгууллагууд

Он	Төрийн өмчийн ЭМБ	Хувийн хэвшлийн ЭМБ	Сувилал	ӨСТЭМТ			Эмийн сан	Дүн
				Өрх	Сум	Тосгон		
2021	2	3	3	3	17	2	32	62
2022	2	3	3	3	17	2	29	59

Эх сурвалж: ЭМДХ-ийн 2021, 2022 оны статистик мэдээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд давхардсан тоогоор 241,575 иргэний тусламж үйлчилгээнд 17,317.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 13,150.9 сая төгрөг олгож 4,179.8 сая төгрөгийн өглөг, 13.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Харин 2022 онд давхардсан тоогоор 152,821 иргэний тусламж үйлчилгээнд 22,349.4 сая төгрөг олгохоор тооцож, 26,517.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 25.0 сая төгрөгийн авлага, 23.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №2 Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн тооцоо /сая.төг/

№	Он	Эхний үлдэгдэл		Олгосон санхүүжилт	Олгохоор тооцсон		Эцсийн үлдэгдэл	
		Авлага	Өглөг		Хүний тоо	Мөнгөн дүн	Авлага	Өглөг
1	2021 он	-	-	13,150.9	241,575	17,317.3	13.5	4,179.8
2	2022 он	13.5	4,179.8	26,517.2	152,821	22,349.4	25.0	23.6
Нийт дүн		13.5	4,179.8	39,668.1	394,396	39,666.7	38.5	4,203.4

Эх сурвалж: ЭМДХ-ийн 2021, 2022 оны статистик мэдээ

²⁴ 4.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ дараах төрөлтэй байна:

I БҮЛЭГ. Эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, салбарын хөгжлийн зорилтуудтай нийцэж байгаа боловч үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

A1.1.Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн зорилт арга хэмжээ, салбарын урт болон дунд хугацааны баримт бичгийн зорилттой нийцэж байна.

УИХ-аас 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэн, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн:

- 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "хөгжлийн бодлого" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;
- 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг;
- 4 дүгээр зүйлийн 4.1.10-д "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;
- 4 дүгээр зүйлийн 4.1.11-т "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ" зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгасан зорилт арга хэмжээ "Алсын хараа-2050" бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилттой нийцэж байна. /Хавсралт №1/

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар баталжээ.

Хүснэгт №3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хүрсэн түвшин	
				2025	2030	2050	2021	2022
1	Хүн амын дундаж наслалт	жил	70.2	74	78	82	71.1	71.3
2	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	тоо	2.9	3.3	3.3	3.5	3	2.5
3	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	13.4	9	8	2.3	17.7	13.4
4	100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	промилль	27.1	20	15	5	0	0
5	Тухайн жилийн товллолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	98.9	99	99	99.5	99.4	99.2
6	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний эзлэх хувь	хувь	71.7	82	93.7	100	47.6	54.7
7	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	3.4	2.5	2	0	0.7	0.5

Эх сурвалж: ЭМГ-ын 2021, 2022 оны статистик мэдээ

Эрүүл мэндийн газрын статистик мэдээнээс харахад Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 2021-2022 онд хүрэхээр зорилт дэвшүүлсэн шалгуур үзүүлэлтээс 100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдэлгүй ажилласан, товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь өссөн, вируст гепатитын өвчлөл буурсан сайн үзүүлэлттэй байна. Харин төрөлтийн коэффициент суурь түвшнээс буурсан нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт 94 хувь байна. Тус гэрээнд Орон нутгийн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачилгатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар тусгажээ. Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/188 дугаар захирамжаар “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөр” боловсруулах ажлыг хэсгийг байгуулж, төслийг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлж, 28 дугаар тогтоолоор “Говь-Алтай аймгийн иргэдийг орон сууцжуулах” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2025 он хүртэл хэрэгжүүлэхээр баталжээ.



Сайн туршлага: Аймгийн Засаг даргын 2023 оны А/171 дугаар захирамжаар “Эрүүл мэндийн даатгалын сангаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгож буй гүйцэтгэлийн санхүүжилтийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажлыг хэсэг байгуулжээ. Ажлын хэсгийн гишүүд аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэг өдрийн ажлын зураглал хийж, программ хангамж серверийн ачааллаас эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг хугацаа хоцорч нэхэмжлэх эрсдэл бий болж, эмч, сувилагч нарт ажлын зохиомол ачаалал үүсэж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Улмаар орон нутгийн төсвөөс 34.0 сая төгрөгийн сервер, таблетийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэхэд дараах хууль эрх зүйн өөрчлөлтийг хийгээгүй байна.

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5-т “Эрүүл мэндийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан боловч өнөөдрийг хүртэл батлаагүй байна.
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 03/8544 дугаар албан бичгийн 3.3-т гүйцэтгэл үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагуудын дансны үлдэгдлийг төвлөрүүлэхгүй тухай чиглэлийг хүргүүлжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байна.

А1.2.ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-д өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тухай хуульд Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна гэж заасан. ЭМДҮЗ нь:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлах
- Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тогтоох
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг батлах зэрэг хуулиар хүлээсэн үүрэгтэй байгууллага юм.

ЭМДҮЗ-ийн баталсан тогтоол, түүнд үндэслэн гарсан журам, тушаалтай холбоотой дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

- Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)-гийн оношилгооны жишиг төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 49/А118 дугаар хамтарсан тушаалаар 0.07 сая төгрөгөөр тогтоосон боловч ЭМДЕГ-ын даргын 2022 оны "Жагсаалт батлах тухай" А/53-р тушаалаар 0.06 сая төгрөгөөр санхүүжүүлж байна.
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 тоот тушаалаар баталсан "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны журам"-ын хоёрдугаар хавсралтад улаан хоолой, ходоодны дуран (хавдар, ходоодны үрэвсэлт өвчин)-гийн оношилгоог 35-аас дээш насанд жилд 1 удаа хийх давтамжтай заасан бол ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад 31-45 насны даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад улаан хоолой, ходоодны дуран гэж насны хувьд зөрүүтэй баталсан.

Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгээс ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Чанар, төлбөрийн хяналтын журам"-тай холбоотой дараах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

- Эмгэг төрөлтүүд төрөх тасагт төрж байгаа боловч "нэг ургийн хэвийн төрөлт" гэж өвчний олон улсын ангиллын кодоор /О80, О81, О83/ багтаан кодолсон байгаа нь төрөлтүүдийг "хэвийн эмгэг төрөлт" гэж зааглах боломжгүй.
- Яаралтай тусламжийн тасагт төрөхөөр ирж байгаа эхчүүдэд "Төрөлтийн I үе" гэсэн код байхгүй тул "Дуншилт /О47/" гэж буруу кодоор авч төрүүлж байгаа алдаа байна.
- Яаралтай тусламжийн тасагт эмэгтэйчүүдийн яаралтай оношоор сонгож хэвтүүлэхээр N онош сонгогдохгүй алдаатай байна. Жишээ нь: Өндгөвчний уйланхай хөл дээрээ мушгирах, хэвлий бага аарцгийн эрхтний гялтангийн үрэвсэл г.м
- Жирэмсний эмгэгийн тасагт умайн хөндийн жирэмсэн, зулбахаар завдаад хэвтэх, "Эрт үеийн үр хөндөлт" гэсэн оношны кодын шалгуур үзүүлэлтээр цусанд "Хориан Гонадотропин" үзэх гэсэн шалгуур байгаа нь алдаатай байна.
- Нярайн шарлалтыг шалгах шалгуур үзүүлэлт нь шарлалтын эмнэлзүй удирдамжаас зөрүүтэй мөн зөвхөн цус задрах өвчний шалгуураар хийсэн нь шарлалтын бүх өвчний түүх шалгуурт нийцэхгүй байна. Жишээ нь шалгуурт: Резус сөрөг цустай байх-ховор тохиолддог, Бүтэлт-Нярай бүр бүтэлттэй төрөхгүй, Цус солих эмчилгээ-Нярай бүрийн цусны бүлэг үзэх, Цусны нянгийн шинжилгээ-Нянгаар үүсгэгдсэн халдварын үед үздэг.
- Резус цус хайлах эсвэл АВО цус хайлах эмгэгийн улмаас ийлдэсний билирубин 8.5 мкмол/л цаг тутам хэмжээгээр нэмэгдсэн тохиолдол, Цус задрах өвчтэй нярайд 1 цагийн дотор иммуноглобулин судсаар хийх, Судсаар кальци хийх /заалт нь шарлалттай нярайн эмнэлзүйд тэр бүр тохирох шалгуур үзүүлэлт болохгүй байна.
- Нярайн тархины хямрал шалгуурт эхокардиограф, цээжний рентген хийх нь эмнэлзүйн хувьд тэр бүр ач холбогдол багатай байна. Эмчилгээний хоолонд заасан интубац тавих гэсэн шалгуур нь нярай бүрд шаардлагагүй байна.
- Эрчимт эмчилгээний В шалгуурт хүүхдийн эрчимт эмчилгээнд инсулин судсаар хийх, плеврийн гуурс, хэвлийн хөндийн гуурс тавих гэсэн шалгуур нь хүүхэд бүрд хийдэггүй, шаардлагагүй. Цусанд /натри, кали, хлор, кальци/ үзүүлэлт хүүхэд нярайн нормоор оруулах.
- Эрчимт эмчилгээний тасагт А бүлгийн шалгуур хангасан өвчтөний санхүүжилтийг А бүлгээр олгодог байх. Аймгийн эрчимт эмчилгээний 2 эмчийн орон тоотой байна. А бүлгийн шалгуур хангаж байгаа өвчтөнүүд 2 болон 3 дугаар шатлалд адилхан тусламж үйлчилгээ авч байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тухайд шинжилгээний шалгуур үзүүлэлтээс шалтгаалж, хүнд өвчтөн энгийн тасагт хэвтэж хүндрэх, үйлчлүүлэгч чанартай тусламж үйлчилгээ авах нь хязгаарлагдаж байна.
- Эрхтэн системийн шинжилгээнээс шалгуур үзүүлэлтэд оруулж өгөх; Зүрхний шигдээс, тархины цус харвалт, эпилепси, үжил, бөөрний дутагдал, элэгний дутагдал, хэвтэн эмчлүүлэх өвчний А болон В шалгуурт шинжилгээнээс натри, кали, кальци сахар гэсэн үзүүлэлт оруулсан нь хүнд өвчтөн болгонд өөрчлөгдөхгүй учир доорх шинжилгээг шалгуурт оруулах. Үжил /цагаан эс, СРБ, Прокальцитонин/ Элэгний дутагдал /АСАТ, АЛАТ, билирубин, тромбоцит, бөөрний эмгэг, креатинин, мочеви, зүрхний шигдээс, тропонин/
- В шалгуурт: Амьсгалын тоог 21-с дээш 11-с доош халуун 38.1-с дээш 36 доош ЗЦТ 45-с доош 120 дээш гэж заасан. Зарим тохиолдолд В бүлгийн хүнийг А бүлгээр шалган хасагдал үүсгэж байна.

А1.3. Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын шалгуур үзүүлэлт, төлбөрийн тарифыг ялгаатай тогтоож өгөх шаардлагатай байна.

Хөгжиж буй орнуудын хувьд эрүүл мэндийн салбарын төсөвтөө хамгийн багадаа дотоодын нийт бүтээгдэхүүний 5-6 хувийг санхүүжүүлэх нь зохистой гэж ДЭМБ-аас зөвлөдөг.

Монгол Улсын хувьд ДНБ-д эзлэх эрүүл мэндийн улсын зардал 3.5 хувь байна. Дэлхийн улс орнуудад эрүүл мэндийн даатгалын тогтолцооны дараах хэлбэр байгаагаас манай улс бүх нийтийн даатгалын тогтолцоогоор иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

- Засгийн газраас санхүүждэг буюу нэг төлбөрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Бүх нийтийн даатгалын тогтолцоо (ЭМД-д заавал хамрагдана, эв санааны зарчим дээр суурилдаг)
- Бүх нийтийн төр, хувийн хэвшлийн даатгалын тогтолцоо;
- Бүх нийтийн хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоо
- Бүх нийтийн бус даатгалын тогтолцоо;

Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмч эмнэлгийн ажилтны цалин, хөлсийг үр дүн, бүтээмжтэй уялдуулах, хувийн хэвшлийг оролцоог нэмэгдүүлэх зэрэг давуу талтай ч хүний нөөц, тоног төхөөрөмжийн хувьд бүрэн хангагдаагүй, цөөн хүн амд үйлчилгээ үзүүлдэг сум, өрх тосгоны эрүүл мэндийн төвийн нөхцөл байдлыг бодитой үнэлэн бодлогын хүрээнд авч үзэх шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл иргэн бүр хаана амьдарч, оршин сууж байгаагаас үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй авдаг байх үндсэн зарчимд тулгуурлан эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Ковид 19 өвчний санхүүжилтэд сумдын Эрүүл мэндийн төвд 2021 онд 3,690.9 сая төгрөг, 2022 онд 857.5 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд:

- Шарга сумын Эрүүл мэндийн төвд 11.0 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон боловч жилийн эцэст 0.9 сая төгрөгийг өглөгтэй
- Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвд 11.0 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон боловч жилийн эцэст 14.0 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.



Зураг 1. Шарга, Халиун сумын Эрүүл мэндийн төвийн барилга


Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Халиун сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг 1,361.0 сая, Шарга сумдын Эрүүл мэндийн төвийн барилгыг 1,356.0 сая төгрөгийн өртөгтэйгээр бариж ашиглалтад оруулсан. Гэвч шинээр ашиглалтад орсон барилгууд нь сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013-д нийцэхгүй байна.

Эрүүл мэндийн төвийн өрөө тасалгааны хүртээмж хангалтгүйгээс өдрийн эмчилгээ, сэргээн засах болон фикик эмчилгээний тусламж үйлчилгээг хуучин эмнэлгийн барилгад үзүүлж байна.

II БҮЛЭГ. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, санхүүжилтийг хянах журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

Б1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлын төлөвлөгөөг үндэслэлгүй, харилцан адилгүй баталсан байна.

Дүрслэл №1 Ажил олгогч хариуцан төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/



ЭМДЕГ-аас Говь-Алтай аймгийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2021 онд 4,281.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 4,032.7 сая төгрөгийн орлого төвлөрч 94.1 хувьтай байгаа бол 2022 онд сангийн орлогын төлөвлөгөөг 6,988.3 сая төгрөгөөр баталж гүйцэтгэл 3,548.5 сая төгрөг төвлөрч 50.8 хувьтай байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т хамаарах шимтгэлийг даатгуулагч, ажил олгогч тэнцүү хувь хэмжээгээр хариуцан төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөө 2020 онд 105 хувь, 2021


онд 94 хувьтай биелсэн боловч 2022 онд 1.6 дахин нэмж баталснаас 2,494.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх даатгуулагчийн орлогын төлөвлөгөөний тухайд:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-6.1.4, 6.1.12³-т заасан даатгуулагч шимтгэлийг хагас жил, эсхүл жил бүр өөрөө хариуцан төлдөг.

Малчид, оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтын 2020, 2021, 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харахад нийт мөнгөн дүнгээр давж биелдэг боловч хамрагдсан хүн амын тоогоор 52-82 хувьтай байна. Тухайлбал 2021 онд 13,150 иргэнээс 459.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцож, гүйцэтгэлээр 6,778 иргэнээс 490.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Гэтэл 2022 оны төлөвлөгөөнд даатгуулагчийн тоог бууруулж 10,100 иргэнээс 945.7 сая төгрөгийн шимтгэл төлүүлэхээр төлөвлөснөөс 8,244 иргэнээс 545.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. /Хавсралт №2/

Дүрслэл №2 Шимтгэлийг нь өөрөө хариуцсан төлөх иргэдийн хамрагдалт



ЭМДЕГ, НДЕГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу сумдын байцаагч нар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж, байцаагчийн урамшуулалд 2021 онд 7.6 сая төгрөг, 2022 онд 5.3 сая төгрөгийг олгосон байна.

³6.1. Хүн амыг эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх байдлаас нь хамааруулан доор дурдсанаар ангилна.

ЭМДЕГ-ын даргын тушаалаар баталсан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны зардлын төлөвлөгөөнд Говь-Алтай аймагт олгох санхүүжилтийг 9,522.1 сая төгрөгөөр баталсан ч гүйцэтгэлээр 22,349.4 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.



Сайн туршлага: Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь аймгийн ЗДТГ-тай хамтран 2022 онд зохион байгуулсан малчдын зөвлөгөөний оролцогч 3000 иргэний ЭМД-ын шимтгэл төлөлтийн дутуу төлөлттэй саруудын судалгааг гарган, ЭМД-д хамруулж, урьдчилан сэргийлэх эрт үзлэг оношилгоонд хамруулсан байна.

Б1.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг хянах журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан эрүүл мэндийн байгууллагаас гэрээний дагуу худалдан авах тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх “Чанар төлбөрийн хяналтын журам”, ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/139 тоот тушаалаар баталсан “Нэхэмжлэлийн хяналтын журам”-ын дагуу нэхэмжлэлийн хяналтыг гүйцэтгэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021-2022 онуудад нийт 32,985.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна. Үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 18,283.2 сая, УАУНЭ-т 1,110.1 сая, хувийн хэвшлийн эмнэлэгт 2,390.2 сая, рашаан сувилалд 373.3 сая, өрх, сум, тосгоны ЭМТ-д 9,034.1 сая, эмийн санд 1,794.8 сая төгрөгийг олгосон байна.

Нэхэмжлэлийн хяналтаар 2021 онд шалгуур үзүүлэлт хангаагүй 8209 иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний 1,323.6 сая, 2022 онд 6959 иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээний 1,803.6 сая төгрөгийг тус тус хасаж тооцсон байна.

Хүснэгт №4 Эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжлэлийн хяналт-2021 он/сая.төг/

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон	
		Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Нэгдсэн эмнэлэг	119505	10,230.1	5925	1,035.5	112927	9,194.6
2	УАУНЭ	1046	410.0	22	23.7	1043	386.3
3	Хувийн эмнэлэг	2349	1,952.7	57	41.2	2307	1,911.5
4	Сувилал	1150	287.9	64	16.5	1086	271.5
5	Өрх, сумын ЭМТ	97909	4,916.1	1776	193.5	96143	4,722.6
6	Эмийн сан	28434	843.8	365	13.2	28069	830.6
	Нийт	250393	18,640.6	8209	1,323.6	241575	17,317.1

Эх сурвалж: ЭМДХ-ийн статистик мэдээ

Хүснэгт №5 Эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжлэлийн хяналт-2022 он/сая.төг/

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгохоор тооцсон	
		Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Нэгдсэн эмнэлэг	92943	10,294.9	2114	1,206.3	90829	9,088.6
2	УАУНЭ	5410	750.0	70	26.2	5340	723.8
3	Хувийн эмнэлэг	1056	559.5	45	80.8	1011	478.7
4	Сувилал	543	122.7	54	20.9	489	101.8
5	Өрх, сумын ЭМТ	27098	4,757.7	3267	446.2	23831	4,311.5
6	Эмийн сан	32725	987.4	1409	23.2	31316	964.2
	Нийт	159,775	17,472.1	6,959	1,803.6	152,816	15,668.5

Эх сурвалж: ЭМДХ-ийн статистик мэдээ

Даатгуулагчдад хөнгөлөлттэй эмээр үйлчлэхээр гэрээ байгуулсан 1-р зэрэглэлийн-1, 2-р зэрэглэлийн 28 эмийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. Гэрээ бүхий 29 эмийн сангийн нэхэмжлэлд хяналт тавьж:

- 2021 онд 28,434 даатгуулагчид олгосон 843.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмийн жоронд хяналт хийж, 13.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, эмч байцаагчийн хасалт хийж, нийт 830.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

- 2022 онд 987.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмийн жоронд хяналт хийж, 23.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, эмч байцаагчийн хасалт хийж, нийт 964.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Эмийн сангийн иргэдэд олгосон и-баримтын эх хувь, эмийн сангийн орлого зарлагын тайланг сар бүр нэхэмжлэлийн хамт авч, программтай тулган шалгаж, эмийн бар код зөрсөн, эмийн тун хэтэрсэн, хурууны хээ шаардаагүй өндөр хөнгөлөлттэй эм бичүүлсэн зарим иргэдийг сонгон авч утсаар холбогдож, эмчилгээний карт, онош баталгаажсан эсэхэд хяналт тавьж хасалт хийсэн байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд 2021, 2022 онд нийт 8,310.0 сая төгрөгийг нэхэмжилснээс 475.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэхэмжлэлийн хяналтаар хасаж 7,835.8 сая төгрөгийг олгосон байна.

Үүнээс нийт санхүүжилтийн 58 хувь буюу 4,548.5 сая төгрөгийг сум, тосгоны ЭМТ, 8.6 хувь буюу 677.1 сая төгрөгийг Нэгдсэн эмнэлэг, 2.1 хувь буюу 161.0 сая төгрөгийг УАУНЭ, 10.3 хувь буюу 805.3 сая төгрөгийг, 21 хувь буюу 1,643.4 сая төгрөгийн хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон байна.

Хүснэгт №6 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тусламж үйлчилгээний санхүүжилт-2021, 2022 он /сая төг/

Тусламж үйлчилгээний төрөл	Сум тосгоны Эрүүл мэндийн төв		Нэгдсэн эмнэлэг		УАУНЭ		Өрхийн эрүүл мэндийн төв		Хувийн эмнэлэг	
	Хүний тоо	Нийт дүн	Хүний тоо	Нийт дүн	Хүний тоо	Нийт дүн	Хүний тоо	Нийт дүн	Хүний тоо	Нийт дүн
Хэвтэн эмчлүүлэх-6,474.3 сая.төг олгосон										
Нэхэмжилсэн	4,460	4,303.1	331	655.1	141	183.9			1,128	1,659.1
Хасагдсан	189	185.0	46	103.7	19	22.4			16	15.7
Олгосон	4,271	4,118.1	285	551.4	122	161.5	-	-	1,112	1,643.4
Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ-833.5 сая.төг олгосон										
Нэхэмжилсэн	1,466	234.6					4,810	746.7		
Хасагдсан	386	61.8					384	86.0		
Олгосон	1,080	172.8	-	-	-	-	4,426	660.7	-	-
Дархлаажуулалт-402.4 сая.төг олгосон										
Нэхэмжилсэн	50,747	257.6	30	0.2			28,934	144.7		
Хасагдсан										
Олгосон	50,747	257.6	30	0.2	-	-	28,934	144.7	-	-
Шинжилгээний сорьц авах-125.6 сая.төг олгосон										
Нэхэмжилсэн			2,515	125.8						
Хасагдсан			3	0.2						
Олгосон	-	-	2,512	125.6	-	-	-	-	-	-
Нийт нэхэмжилсэн	56,673	4,795.2	2,876	781.0	141	183.9	33,744	891.4	1,128	1,659.1
Нийт хасагдсан	575	246.7	49	103.8	19	22.4	384	86.0	16	15.7
Нийт олгосон	56,098	4,548.5	2,827	677.1	122	161	33,360	805.3	1,112	1,643.4

Эх сурвалж: ЭМДХ-ийн статистик мэдээ

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4-т “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г төр хариуцахаар заасан боловч Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын санхүүжилтийг ЭМДС-аас олгосон байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн цахимын хасалт нь дараах шалтгаантай байна.

- Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээг нэхэмжилсэн
- Оношийн хамаарлын бүлгийн нэр, ангиллыг зөрүүтэй илэрхийлсэн
- Амбулатори, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлсэн иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давхардуулсан

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн байцаагчийн хасалт нь дараах шалтгаантай байна.

- Програмаар шивсэн боловч баримт, нэхэмжлэл ирүүлээгүй
- Нэхэмжлэлийн хугацаа хоцроосон
- Төлбөрийн и-баримтгүй
- Ерөнхий болон эмнэлзүйн шаардлага хангаагүй
- Өвчтөний түүхэд оношилгоо, шинжилгээний хуудас хавсаргаагүй
- Хурууны хээ уншаагүй, бодит цагийн горим баримтлаагүй
- Анхан шатны маягтыг дутуу хөтөлсөн
- Оношийн зөрүүтэй нэхэмжилсэн

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.10-т эрүүл мэндийн үйлчилгээ татвараас чөлөөлөгдөхөөр заасан тул нэхэмжлэлийн үндсэн шалгуурт төлбөрийн баримт хэвлэсэн эсэх үзүүлэлтийг оруулах шаардлагагүй байна.

Аудитаар нэхэмжлэлийн хяналт, санхүүжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн оношилгоонд хамрагдсан иргэдээс дурангийн оношилгоо хийлгэхээс татгалзсан тусламж үйлчилгээний төлбөрийг бүхлээр нь хасаж, 23.7 сая төгрөгийг дутуу олгосон
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн оношилгоонд хамрагдсан иргэдээс дурангийн оношилгоо хийлгэхээс татгалзсан тусламж үйлчилгээний төлбөрийн хэсэгчлэн хасалгүйгээр 11.1 сая төгрөгийг илүү олгосон
- Цахим программын өөрчлөлттэй холбоотой гэх шалтгаанаар 2022 оны 07-10 дугаар сарын хэвтэн эмчлүүлэх, яаралтай, түргэн тусламж, шүдний тусламж үйлчилгээний нэхэмжлэхийг хяналгүйгээр 2,033.5 сая төгрөгийн санхүүжилтийг шууд олгосон
- Өвчний түүхийг түүвэрт хамруулан шалгахад үндсэн онош зөрүүтэй, оношийг батлах шинжилгээ оношилгоо хийгдээгүй, үндсэн болон ялгах онош бичээгүй, эмчийн үзлэгийн тэмдэглэл хийгээгүй зэрэг зөрчилтэй ЭМДХ-ээс түүвэрлэгдээгүй нэхэмжлэлээр 2.6 сая төгрөгийг ЭМДС-аас санхүүжилт олгосон байна.
- Төлбөрийн нэхэмжлэлд хяналт хийсэн тухай албан бичгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хасалтын дэлгэрэнгүй мэдээллээр бүрэн хангадаггүй
- Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)-гийн оношилгооны жишиг төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022/02/28-ны өдрийн 49/А118 дугаар хамтарсан тушаалаар 0.07 сая төгрөгөөр тогтоосон боловч ЭМДЕГ-ын даргын 2022 оны "Жагсаалт батлах тухай" А/53-р тушаалаар 0.06 сая төгрөгөөр санхүүжүүлснээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон.

Б1.3.Эрүүл мэндийн даатгалын хэлтэс батлагдсан орон тооноос 1 орон тоо дутуу ажиллаж байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/10 тушаалаар бүтцийн нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж тус аймагт хэлтсийн дарга 1, мэргэжилтэн 4 нийт 5 орон тоо баталсан. Гүйцэтгэлээр хэлтсийн дарга 1, зардал төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтэн 1, чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2 ажиллаж байна. Төрийн албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруултыг зарлаагүй байна.

Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг боловсон хүчний хувийн хэрэгтэй тулган баталгаажуулахад ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрдэнэ” гэж заасан боловч бүтэц орон тоонд батлагдаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь төсвийн шууд захирагчийн эрхгүй, ЭМДЕГ-аас цалин, хөдөлмөрийн хөлсийг тооцож, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг байна.

Б1.4.Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан боловч анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудтай шууд гэрээ байгуулсан байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг 2021 онд сонгон шалгаруулахгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁴ дэх заалтыг зөрчсөн байна.

ЭМДЕГ-аас 2022 онд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын материалыг <https://selection.1818.mn> цахим системээр хүлээн авч сонгон шалгаруулсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, УАУНЭ, хувийн хэвшлийн 3 эмнэлэг, 2 сувилал сонгон шалгаруулалтад тэнцсэн байна.

Аудитаар эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах 4 багц тусламж, үйлчилгээг үзүүлэх төв, орон нутгийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтээр үнэлж үзэхэд сумын эрүүл мэндийн төвүүд зарим тусламж үйлчилгээний тусгай шаардлагыг хангахгүй байна.

Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэгдсэн хүний нөөц байхгүй, оношилгоо шинжилгээний шаардлага хангасан өрөөгүй, шинжилгээ хийх багаж төхөөрөмжгүй зэрэг шалтгаанаар сонгон шалгаруулалтын босго ононд хүрэхгүй байна. /Хавсралт №3/

Мөн аудитаар түүвэрлэн үзэхэд аймгийн Нэгдсэн эмнэлгийн зарим тусламж үйлчилгээ сонгон шалгаруулалтын хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн тусгай шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал соронзон резонанс томографийн аппарат, ангиографийн аппарат байхгүй, мэдрэлийн мэс заслын эмч, хүүхдийн зүрх судлалын эмч, ревматологич эмч, бөөр судлалын эмч зэрэг 11 эмчлэх боловсон хүчин дутагдалтай байна.

Б1.5.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын 2021 оны даатгалын гэрээ дүгнэх үзүүлэлт нь хэт ерөнхий, 2022 онд эмийн сангаас бусад байгууллагын гэрээг дүгнээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2021-2022 онд нэгдсэн эмнэлэг, УАУНЭ, ӨСТЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг болон 29 эмийн сан нийт 59 байгууллагатай эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг байгуулсан байна.

ЭМДЕГ-тай 2021 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр лавлагаа шатлалын 5 эмнэлэг, анхан шатны буюу сум, өрх, тосгоны 22 эрүүл мэндийн төв, 32 эмийн сан, 3 сувилал гэрээ байгуулсан байна.

Гэрээ дүгнэсэн байдал-Эмийн сан

Хөнгөлөлттэй эмээр үйлчлэхээр 2021 онд гэрээ байгуулсан 3 эмийн сан татан буугдсан тул гэрээг дүгнээгүй байна.

“Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний 2021 оны дундаж 85.7 хувьтай, 2022 оны дундаж 82.5 хувьтай байна. Стандартад заасан хүний нөөцгүй, анхан шатны бүртгэл маягыг стандартын дагуу хөтөлдөггүй, зохистой жор бичилтийг төлөвшүүлэхэд харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй, байцаагч эмчийн жорын хасагдалтай зэрэг үзүүлэлтүүдэд оноо алдсан байна.

Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартад 2 дугаар зэрэглэлийн эмийн сангийн орон тооны шалгуурт эмийн сангийн жор баригч, үйлчлэгчийг үндсэн орон тоонд ажиллуулахаар заасан. Орон нутгийн эмийн сангуудад худалдан авагчийн тоо хязгаарлагдмал, бараа бүтээгдэхүүний эргэлт багатайгаас стандартад заасан орон тоогоор үйл ажиллагаа эрхлэхэд санхүүгийн хүндрэл үүсч байна.

Гэрээ дүгнэсэн байдал-Эмнэлэг

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан 19 сумын Эрүүл мэндийн төв, 3 ӨЭМТ-ийн гэрээний хэрэгжилтийг 15 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд биелэлт дунджаар 85.3 хувьтай байна. Лавлагаа шатлалын аймгийн Нэгдсэн эмнэлэг, УАУНЭ,

⁴10.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ.

хувийн хэвшлийн 3 эмнэлэг 95 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Бигэр шимт элс сувилал 90 хувь, Нар элс сувилал 85 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Эмийн сан, эрүүл мэндийн төвийн гэрээ дүгнэсэн шалгуур үзүүлэлтийг нэгтгэн дүгнэхэд гэрээний зүйл заалтад хамааралгүй, сонгон шалгаруулалтын тусгай шаардлагын зарим үзүүлэлтээр дүгнэсэн, хэт ерөнхий шалгуур тавьсан нь гэрээг бодитой дүгнэхэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гэрээнд боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангалт, төсвийн төсөөллийг гэрээнд заасан хугацаанд ирүүлсэн эсэх зэрэг шалгуур үзүүлэлт гэрээнд тусгаагүй байхад гэрээ дүгнэх үнэлгээний хуудсанд оруулж дүгнэсэн.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 тогтоолын хавсралтаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор лавлагаа шатлалын эмнэлгийг сонгон шалгаруулалт хийж, гэрээг 3 жилийн хугацаатайгаар дахин байгуулсан байна.

ЭМДЕГ-аас шалгуур үзүүлэлтийг шинэчилж ирүүлээгүй тул аймгийн Нэгдсэн эмнэлэг, ӨСТЭМТ, рашаан сувилал, хувийн хэвшлийн эмнэлгийн 2022 оны гэрээг өнөөдрийг хүртэл дүгнээгүй байна.

Б1.6.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн зөрчил буурахгүй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас 2021 онд 13,150.9 сая төгрөгийн, 2022 онд 26,517.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төрийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,473.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй, аймгийн Нэгдсэн эмнэлэг 812.9 сая, Шарга сумын ЭМТ 11.9 сая, Гуулин тосгоны ЭМТ 25.0 сая төгрөгийн өглөгтэй байна. Тус хоёр сумын Эрүүл мэндийн төв нь санхүүжилт хүрэлцэхгүйн улмаас ЭМДС-аас урьдчилгаа санхүүжилт авсан байна.

Төрийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДС-аас олгосон санхүүжилтийн захиран зарцуулалтад Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж дүгнэлт, шийдвэрийг төсөв захирагч нарт хүргүүлжээ. Үүнд:

- 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” 14, “Хязгаарлалттай” 10 санал дүгнэлт авсан байна. Нийт 4,128.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 2,393.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 20.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,714.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 19 заалт бүхий зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.
- 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” 12, “Хязгаарлалттай” 12 санал дүгнэлт авсан байна. Нийт 2,419.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, аудитын явцад 1,004.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 40.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,373.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 6 заалт бүхий зөвлөмж, 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг харилцан адилгүй үзүүлэлтээр дүгнэж байна. Тухайлбал сумдын Эрүүл мэндийн төвүүд албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн шалгуур үзүүлэлт байхгүй, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлт нь хэт ерөнхий байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээг үзүүлэхээр гэрээ байгуулсан боловч 3424 тохиолдлын 309.3 сая төгрөгийн санхүүжилтийг огт нэхэмжлээгүй байна. /Хавсралт №4/

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч чадаагүй, хасагдсан нэхэмжлэлийн шалтгааныг нэгтгэн дүгнэхэд 82.4 сая төгрөгийн нэхэмжлэх нь эрүүл мэндийн байгууллага, ажилтны ажлын хариуцлагатай шууд холбоотой байна. /Хавсралт №5/ Нэхэмжлэлийг хугацаа хоцроож ирүүлдэг, анхан шатны маягтыг дутуу хөтөлдөг зэргээс тусламж үйлчилгээний төлбөрийг ЭМДС-аас авч чадахгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь сонгон шалгаруулалтын тусгай шаардлагыг хангасан боловч баримт, материалаа хүргүүлээгүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих боломжтой зүрхний холтерийн оноштой өвчтөнөөс 0.6 сая төгрөгийн төлбөрийг иргэдээр төлүүлсэн байна.

III БҮЛЭГ. Цахим системийг эрүүл мэндийн даатгалын чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоотой нийцүүлснээр дэвшил гарахаар байна.

Б2.1. Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулж байгаа хэдий ч зонхилон тохиолдох өвчлөлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх ажил дутмаг байна.

Эрүүл мэндийн газраас тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа зорилтот бүлгийн болон алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021, 2022 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

2021 он:

- Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 2021 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарын баг, аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран зохион байгуулж Баян-Уул, Хөхморьт, Дарив, Халиун, Дэлгэр, Чандмань сум, Гуулин тосгоны нийт 4021 хүнийг хамруулан, 83 хүнийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үзүүлэхийг зөвлөсөн байна. Үзлэгт хамрагдвал зохих хөдөөгийн 7915 малчин өрхийн 13128 иргэнээс 2032 малчныг буюу 15.5 хувийг явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. Зорилт арга хэмжээний хэрэгжилтийг 68.4 хувьтай дүгнэсэн байна.
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, тусламж үйлчилгээний чанар хөтөлбөрийг сайжруулах зорилтын хүрээнд төлөвлөсөн эмч, сувилагч, асран хамгаалагчийг сургалтад хамруулах, аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Настны кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулах, настны эмч сувилагчийг бэлтгэх” арга хэмжээ ковид 19 цар тахлын улмаас хэрэгжээгүй байна.
- Харьяа байгууллагын 19 эрүүл мэндийн төв, 3 өрхийн эмнэлэгт давхардсан тоогоор 2430 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Зорилт арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.

2022 он:

- “Хавдаргүй монгол эмэгтэй” нийгмийн зорилтот төслөөр 18 сум, 2 тосгонд явуулын тусламж, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 2207, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 2407 эмэгтэй, дотрын эмчийн үзлэгт 736, арьс харшлын үзлэгт 52, ДОХ, серологи, элэгний В, С вирус, хеликобактерийн шинжилгээнд 3146 эмэгтэй хамрагдсан.
- “Мишээл” хүүхдийн сантай хамтран Цогт, Алтай сумдын 3-18 насны нийт 1055 хүүхдийг шүдний үзлэгт хамруулсан.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллага, албан тушаалтан статистик тоон мэдээг олон төрөл хэлбэрээр гаргаж байгаа боловч өвчлөл нэмэгдсэн учир шалтгаан, өвчлөлийг бууруулахад шаардагдах хүчин зүйлст дүн шинжилгээ хийж тайлагнах, тусламж үйлчилгээнд хамруулах ажил хангалтгүй байна.

Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013 стандартад гэрийн идэвхитэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байхаар заасан боловч сумдын Эрүүл мэндийн төвүүд 2021 онд 5.9 сая, 2022 онд 4.8 сая төгрөгийн гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-аас авсан нь тус чанарын шалгуур үзүүлэлт хангагдахгүй байгааг илтгэж байна.

Шарга сумд хөнгөлөлттэй эмээр үйлчлэхээр гэрээ байгуулсан эмийн сан байхгүйгээс тус сумын иргэд төрөөс олгож буй эмийн үнийн хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдаж чадахгүй байна.

Б2.2. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг нэхэмжлэх цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь хэсэгт эрүүл мэндийн даатгалын байгууллага нь “Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх” чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан. Тус чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ.

- Даатгуулагч иргэд ЭМБ-аар тусламж, үйлчилгээ авах үед ямар өвчний үед ямар хэмжээний төлбөрийг даатгалын байгууллага хөнгөлөх боломжтой эсэхийг www.health.gov.mn/check холбоосоор орж лавлах боломжтой

- Даатгуулагч иргэн нь даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчилүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан өөрийн түүхийг харах, хянах боломжтой edaatgal аппликейшныг гар утсандаа суулгаж мэдээлэл авах боломжтой
- Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар түргэн шуурхай хүргэх emongolia системд даатгал төлөлтийн түүхээ харах үйлчилгээг оруулж иргэний лавлагаа бүртгэлийн мэдээллийн системтэй холбосон
- Иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ и баримтын цахим системээр төлөх боломжтой
- Эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлсэн эсэхийг иргэдтэй хамтарч хяналт тавих SMS-PUSH үйлчилгээг нэвтрүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь www.health.gov.mn цахим системийг үйл ажиллагаандаа ашиглаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын ашиглаж байгаа программаас хөрвүүлэлт хийн татан авч, тусламж үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн нэхэмжлэлд хяналт хийж, санхүүжилтийг олгож байна.

Даатгалын байгууллагад ашиглагдаж байгаа тус программын мэдээллийн баазаас дүн шинжилгээ хийх нэгтгсэн мэдээлэл татагдахгүй, зөвхөн сар бүрээр, даатгуулагч бүрээр орж мэдээллийг авч байгаа нь ажлын ачаалал нэмж байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөр хоорондоо уялдаагүй, мэдээллээ хоорондоо солилцдоггүй олон программ хангамж дээр ажиллаж, цаасан болон цахим бүртгэлийг давхар хөтөлж байна.

Хүснэгт №7 Эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамж

№	ЭМБ-ын ангилал	ЭМБ-ын нэр	Ашиглаж буй программ хангамж	Хүндрэл бэрхшээл
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, УАУНЭ	E-health цахим эрүүл мэндийн систем	Серверийн ачаалал их, оношийн бүлгийг гараас оруулдаг тул механик алдаа гарах эрсдэлтэй. Иргэн ЭМД төлсөн эсэх, тусламж үйлчилгээ давхардсан эсэх нь харагдахгүй, гацалт ихтэй, нэхэмжлэлийн дүн буруу тооцоолдог, нэг нэхэмжлэлийг 2 удаа илгээж цахим хасалт үүсдэг.
2	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Энхийн зуун, Эрүүл ирээдүй, Машид эрдэнэ эмнэлэг	Hinfo.mn, eclinic эрүүл мэндийн нэгдсэн платформ	
3	Өрхийн болон сумын ЭМТ	18 сум, 2 тосгон, 3 ЭЭМТ	E-hospital программыг хэрэглэж байсан. 2023 оноос ehealth.mn цахим эрүүл мэндийн систем	
4	Сувиллууд	Бигэр элс, Нар элс	Wings эмнэлгийн программ	
5	Эмийн сангууд	19 суманд байрлах эмийн сангууд	Orion, Maprad, Infosystems эмийн сангийн бүртгэлийн программууд	

Аудитад хамрагдсан хувийн хэвшлийн эмийн сангуудаас асуулга тодруулга авахад эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгож буй эмийн үнийн бар кодыг LICEMED программтай уялдуулан шуурхай шинэчилдэггүйгээс бизнесийн үйл ажиллагаанд хохирол учирдаг байна.

Б2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол буурахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-т зааснаар Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байна. Тухайлбал:

- Е даатгал гар утасны аппликейшныг аймгийн хэмжээнд 920 иргэн гар утсандаа татан ашиглаж байна.
- Орон нутгийн Алтай телевизэд 4 удаа, олон нийтийн Алтай радиод 3 удаагийн ярилцлага, мэдээлэл өгсөн байна.


- Эрүүл мэндийн газартай хамтран ӨСТЭМТ-ийн 80 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цахимаар сургалт зохион байгуулсан байна.
- Гэрээт эрүүл мэндийн байгууллагууд болон Эрүүл мэндийн даатгалын хэлтсээр үйлчлүүлсэн 525 иргэнээс санал асуулга, сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг аудитаар үзэхэд Төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16⁵ дугаар зүйлд заасан хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Өргөдөл гомдлыг хүлээн авсан байгууллагууд нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4.5-д “Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын бүртгэлд болон албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэж, бүртгэл-хяналтын карт хөтлөн, асуудлыг хариуцан шийдвэрлэх ажилтанд шилжүүлнэ.” гэж заасны дагуу тусдаа өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст иргэд, олон нийтээс өргөдөл, гомдол ирүүлээгүй байна.

Дүрслэл №3 Өргөдөл гомдлын агуулга



Эрүүл мэндийн газар, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 7048-1111 утас болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой 2021 онд 31, 2022 онд 101 өргөдөл, гомдол, цаг үеийн шинжтэй санал хүсэлт ирсэн байна.

Үүний 18 хувь буюу 26 нь эмч, ажилчдын ур чадвар, харилцаа

хандлага, ёс зүйтэй холбоотой, 18 хувь буюу 27 нь эмчилгээний чанар хүртээмжтэй холбоотой, 45 хувь нь буюу 65 нь эмчилгээний төлбөр, дэмжлэг хүссэн, үлдсэн 19 хувь нь буюу 27 өргөдөл цаг үеийн шинжтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хүрээнд 11 эмч, эмнэлгийн ажилтанд хариуцлага тооцсон байна. Цаашид эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцааны ур чадварыг сайжруулах нөлөөллийн ажил зохион байгуулах, нэг хүнд ногдох үйлчлүүлэгчийн тоог бууруулж ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдээс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8⁶-т заасны дагуу эм, эмнэлгийн хэрэгслийг өөрөө гаргасан төлбөрийг буцаан авах хүсэлт гаргасан 15 иргэнд 6.1 сая төгрөгийг буцаан олгосон байна.

Манай байгууллагаас “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өвчтөн эмчилгээний явцад өөрөөсөө хэрэглэн эрүүл мэндийн байгууллагаас нэхэмжилсэн 7.4 сая төгрөгийн эмийн үнийг олгоогүй зөрчилд төлбөрийн акт

⁵1.Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

2.Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.

⁶13.1.8.даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох;

тогтоож буцаан олгосонтой холбоотой эмчилгээний төлбөр хүссэн өргөдлийн тоо нэмэгдсэн байна.

Иргэд, олон нийтийн зүгээс ихэвчлэн лавлагаа шатлалын эмнэлэг, аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Эрүүл мэндийн газарт хандан өргөдөл, гомдол гаргадаг байна. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 2021, 2022 онд нийт 4 өргөдөл ирсэн байна.

IV БҮЛЭГ. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутмаг, сумдын чанарын албаны үйл ажиллагаа жигдрээгүй байна.

Б3.1.Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар баталжээ. Тус шалгуур үзүүлэлтэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг Эрүүл мэндийн газар жилийн эцсийн статистик мэдээнд үндэслэн гаргасан бөгөөд 2021-2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувьтай байна. /Хавсралт №6/

Эрүүл мэндийн газраас 2022 онд Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд 37 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүргүүлсэн байна.

Б3.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боловсон хүчин дутагдалтай, сумдын чанарын албаны үйл ажиллагаа жигдрээгүй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын хяналттай холбоотой дараах хууль, эрхзүйн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

- Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Эрүүл мэндийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, шалгах, дүгнэх, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар шалгалт хийх, шалгалтын дүнг мэдээлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг буруутай албан тушаалтнаар арилгуулах, хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд энэ хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх чиг үүргийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналт хариуцсан алба хэрэгжүүлнэ"
- Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 116/А/565 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Эрүүл мэндийн бүх байгууллагуудад "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба" ажиллана.
- Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2019 оны А/565 дугаар тушаал

Аудитаар төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын чанар, аюулгүй байдлын баг томилсон тушаал, чанар, аюулгүй байдлын төлөвлөгөө, хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхэд дараах алдаа зөрчил илэрч байна.

- Чанар аюулгүй байдлын багийг шинэчлэн томилдоггүй, ажлаас гарсан албан хаагчид хариуцуулсан тушаал хүчин төгөлдөр байдаг
- Чанар аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулдаггүй, батлуулсан ч хэрэгжилтийг тайлагнадаггүй
- Эрүүл мэндийн газарт хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг ирүүлдэггүй
- Үйлчлүүлэгчээс авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгадаггүй

Эрүүл мэндийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2020 оны А/625 дугаар тогтоолоор батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийг шалгахад Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эмийн нэр төрлөөс 40-50 хувь нь хэрэглэгдэж байна.

Зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийг тусламж үйлчилгээний төрлийг харгалзан бүлгийн нэршлээр батлаагүйгээс хэрэглэгдэхгүй эмийн нөөц үүсгэн актлах эрсдэл үүсэж байна.

Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2017, Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5081:2013, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5292:20179, "Бүтэц, орон тоо батлах тухай" шалгуур үзүүлэлт болгон боловсон хүчний нөөцийг үзэхэд:

- Орон тооны стандарт нормативаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын орон тоог тооцоход 97 орон тоо хэрэгцээтэй, 7 орон тоо илүүдэлтэй, эрх бүхий албан тушаалтны баталсан тушаалаар тооцоход 29 орон тоо дутуу, 11 орон тоо илүү ажиллаж байна. Нэгдсэн эмнэлгийн бүтэц орон тоог стандарттай харьцуулахад 11 орон тоо хэрэгцээтэй, 3 орон тоо илүүдэлтэй, байгууллагын даргын баталсан орон тоотой харьцуулахад 13 орон тоо дутуу, 7 орон тоо илүү ажиллаж байна.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, зөвшөөрөл олгосон төрлөөс өөр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа 14 мэргэжилтэн, албан тушаалын тодорхойлолтод нийцээгүй 10 албан хаагч байна.
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангийн стандартаар үндсэн орон тоонд ажиллавал зохих 7 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг 40 буюу давхар ажил эрхлэлтээр тайлагнасан.
- Нийт 4 сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгал хариуцсан мэргэжилтэн томилж, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлийг 30 хүртэлх хувиар тооцон олгож байна.

Б.3.3. Эрүүл мэндийн газраас хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж байна.

ЭМДЕГ-аас аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах" гэрээний хэрэгжилтэд эмнэлзүйн аудит хийж тусламж үйлчилгээний шаардлага хангаагүй 144 даатгуулагчийн 310.0 сая төгрөгийн санхүүжилтэд төлбөрийн акт тогтоосон байна.

Аймгийн МХГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааны чанар, эмчилгээний стандартыг мөрдөлтөд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газраас УИХ-д" Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай" хуулийн төсөл өргөн барьсантай холбоотой байна.

Аймгийн ЭМГ-аас 2021 онд Шарга сумын Эрүүл мэндийн төв, Есөнбулаг сумын Энх-Алтай ӨЭМТ, Марал-Алтай ӨЭМТ, Жаргалан-Алтай ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын дагуу шалгуур үзүүлэлтээр 16 сумын 15 хувийн эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, дүнг эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар 2022 оны 11-р сарын 28-ны өдөр хэлэлцүүлсэн байна. Мөн Тонхил, Дарви, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир сумдын эрүүл мэндийн төв, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд шалгуур хуудсаар хяналт, үнэлгээ хийсэн байна.

ДҮГНЭЛТ

"Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХҮН АМ ЦӨӨН, АЛСЛАГДМАЛ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГИЙГ ХАРГАЛЗАН САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООСНООР ИРГЭДЭД ХҮРЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ САЙЖРАХААР БАЙНА.

Аудитаар нийт 2,465.2 сая төгрөгийн алдаа, зөрчилтэй асуудал илрүүлснээс 2,033.5 сая төгрөгийн 11 асуудлыг нэгтгэсэн тайланд тусгуулахаар, 25.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох саналыг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Нийт 13.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 392.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6 заалт зөвлөмж хүргүүлсэн.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ НЭГДСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХААР ДАРААХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА. ҮҮНД:**Хууль эрхзүй, бусад асуудлын хүрээнд тусгуулах санал:**

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-т "Эрүүл мэндийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж заасан боловч өнөөдрийг хүртэл батлаагүй байна.
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 03/8544 дугаар албан бичгийн 3.3-т гүйцэтгэл үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагуудын дансны үлдэгдлийг төвлөрүүлэхгүй тухай чиглэлийг хүргүүлжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай зөрчилдөж байна.
- Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эмийн нэр төрлөөс 40-50 хувь нь хэрэглэгдэж байна. Зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийг тусламж үйлчилгээний төрлийг харгалзан бүлгийн нэршлээр батлаагүйгээс хэрэглэгдэхгүй эмийн нөөц үүсгэн акталж үргүй зардал гарах эрсдэл үүсэж байна.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх төлбөрийг ЭМДЕГ-аас гэрээнд заасан хугацаанд санхүүжүүлэхгүй, гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй байна.
- Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн /Говь-Алтай/ орлогын төлөвлөгөөний биелэлтийг хамрагдсан иргэнээр тооцвол 2021 онд 52 хувьтай, 2022 онд 82 хувьтай, 400.2 сая төгрөгөөр тасарсан. Хүн амын статистик тоо мэдээнд суурилан хамрагдвал зохих хүн амын тоонд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.
- Цахим программын хөгжүүлэлт, тохируулгын асуудлаас шалтгаалан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн санхүүжилтийг бүрэн авч чадахгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах тусламж, үйлчилгээг үзүүлэх төв, орон нутгийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.
- Цахим программын өөрчлөлттэй холбоотой гэх шалтгаанаар 2022 оны 07-10 дугаар сарын хэвтэн эмчлүүлэх, яаралтай, түргэн тусламж, шүдний тусламж үйлчилгээний нэхэмжлэхийг хяналгүйгээр 2,033.5 сая төгрөгийн санхүүжилтийг шууд олгосон.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн эрх зүйн статус тодорхойгүй байна. Тухайлбал өрхийн эрүүл мэндийн төв санхүүгийн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцохоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/05 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан гэрээний үлгэрчилсэн загварт тусгасан боловч хариуцлага тооцох эрх бүхий албан тушаалтан тодорхойгүй байна.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих төлбөрийн жишиг хэмжээг газар зүйн байршил, хүн амын тооноос хамааруулан ялгаатай тогтоох шаардлагатай байна.

Төлбөрийн акт тогтоохоор хүргүүлж байгаа санал:

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн оношилгоонд хамрагдсан иргэдээс дурангийн оношилгоо хийлгэхээс татгалзсан тусламж үйлчилгээний төлбөрөөс нийт дүнгээр хассан 23.7 сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрийн сангийн 10005002002 тоот дансанд төвлөрүүлэх

- Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)-гийн оношилгооны жишиг төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022/02/28-ны өдрийн 49/A118 дугаар хамтарсан тушаалаар 70.0 мянган төгрөгөөр тогтоосон боловч ЭМДЕГ-ын даргын 2022 оны "Жагсаалт батлах тухай" А/53-р тушаалаар 60.0 мянган төгрөгөөр санхүүжүүлснээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт дутуу олгосон 2.0 сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрийн сангийн 10005002002 тоот дансанд төвлөрүүлэх

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ:

ЗӨВЛӨМЖ:

- Чанар аюулгүй байдлын баг томилоогүй, төлөвлөгөө батлуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах
- Орон тооны стандарт нормативт нийцүүлэн анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын орон тоог батлах
- Эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгож байгаа асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх
- Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах 4 багц тусламж, үйлчилгээг үзүүлэх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг тусгай шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авч ажиллах

АЛБАН ШААРДЛАГА:

- Албан тушаалын тодорхойлолтод нийцсэн мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулах
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангийн тусгай зөвшөөрлийг олгохдоо боловсон хүчний тусгай шаардлагыг харгалзан үзэх
- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүрэн нэхэмжлэх арга хэмжээг авах
- Эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтны хариуцлагыг дээшлүүлж, хасагдлыг бууруулах арга хэмжээ авах

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ:

ЗӨВЛӨМЖ:

- Төлбөрийн нэхэмжлэлд хяналт хийсэн тухай албан бичгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хасалтын дэлгэрэнгүй мэдээллээр бүрэн хангаж байх

ТӨЛБӨРИЙН АКТ:

- Өвчний түүхийг түүвэрт хамруулан шалгахад үндсэн онош зөрүүтэй, оношийг батлах шинжилгээ оношилгоо хийгдээгүй, үндсэн болон ялгах онош бичээгүй, эмчийн үзлэгийн тэмдэглэл хийгээгүй зэрэг зөрчилтэй ЭМДХ-ээс түүвэрлэгдээгүй нэхэмжлэлээр олгосон 2.6 сая төгрөгийг холбогдох Эрүүл мэндийн төвүүдээр төлүүлж, ЭМДЕГ-ын эрүүл мэндийн даатгалын сангийн 100900020080 тоот дансанд төвлөрүүлэх

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ:

ТӨЛБӨРИЙН АКТ:

- Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн оношилгоонд хамрагдсан иргэдээс дурангийн оношилгоо хийхээс татгалзсан тусламж үйлчилгээний төлбөрт олгосон 11.1 сая төгрөгийг ЭМДЕГ-ын эрүүл мэндийн даатгалын сангийн 100900020080 тоот дансанд төвлөрүүлэх


АЛБАН ШААРДЛАГА:

- Тусгай шаардлагад нийцэж байгаа тусламж үйлчилгээний нэмэлт сонгон шалгаруулалт зарлагдсан тохиолдолд баримт материалаа хүргүүлэх
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр гэрээ байгуулсан тусламж үйлчилгээний сонгон шалгаруулалтын тусгай шаардлагыг хангуулах арга хэмжээ авах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС82130, Говь-Алтай аймаг, Алтай хот
Утас/Факс: (976) 7048-3483, И-мэйл: gov-altai@emd.gov.mn
Вэбсайт: www.emd.gov.mn

2023.05.19

№

16/84

танай

-ны №

-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан
санхүүжилтийн тогтоолцоо, үр нөлөө”-нд хийсэн
аудитын тайлантай танилцлаа.

Манай хэлтэст өгсөн зөвлөмж болон эрүүл
мэндийн байгууллагуудад өгсөн шийдвэрийг
хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА

Б.ЭНХЦЭЦЭГ

822200021

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**82091 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг
Утас/Факс: 70-48-40-66


2023.05.19 № 326

танай _____-ны № _____-т

Г АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн
гүйцэтгэлийн аудиттай танилцлаа.

Шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА  Г.ЛХАГВАЖАРГАЛ

D: /MyDocuments/ A-5

ХАВСРАЛТ**Хавсралт №1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа**

№	Зорилт	Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат (2021-2030) Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө:	Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
1	1.Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна				
2	2.Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.		2.2.5.гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.		2.1.5.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж,эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлнэ.
3	3.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.				2.1.7.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4	4.Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.				2.1.8.Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.
5	5.Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна.				2.2.2.Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг дадал болгон сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

6	6.Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна.		2.1.12 Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх		2.1.3.Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.
7					2.1.4.Яаралтай тусламжийн чанар хүртээмж, чадавхийг сайжруулж,парк шинэчлэлийг хийнэ.
8					2.1.9.Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй, стандарт хангасан орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
9	7.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.				2.1.1.Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авах чадавхыг бүрдүүлнэ.
10	8.Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна.				
11	9.Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна.				
12	2.1.11 Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх				2.1.6.Цахим үйлчилгээг өргөжүүлж, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ.
13	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх				

Хавсралт №2 Шимтгэлийн өөрөө хариуцан төлөх иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/

№	Сумын нэр	2021 он						2022 он					
		Орлогын төлөвлөгөө		Биелэлт		Давсан+, тасарсан-		Орлогын төлөвлөгөө		Биелэлт		Давсан+, тасарсан-	
		Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
1	Алтай	258	10,500	130	9,291	-128	-1,209	250	23,325	151	9,861	-99	-13,464
2	Баян-Уул	410	18,621	332	25,728	-78	7,107	450	42,325	285	19,534	-165	-22,791
3	Бигэр	412	19,362	283	18,134	-129	-1,228	350	41,849	241	16,319	-109	-25,530
4	Бугат	450	20,712	356	25,724	-94	5,012	450	48,549	224	14,474	-226	-34,075
5	Дарви	388	16,102	251	17,668	-137	1,566	300	35,329	242	15,334	-58	-19,995
6	Дэлгэр	378	17,284	228	17,194	-150	-90	350	37,693	229	16,082	-121	-21,611
7	Жаргалан	308	11,500	174	12,502	-134	1,002	210	26,125	86	4,898	-124	-21,227
8	Тайшир	258	9,000	121	9,432	-137	432	150	21,125	146	8,732	-4	-12,393
9	Тонхил	358	18,900	243	19,661	-115	761	340	40,925	197	13,249	-143	-27,676
10	Төгрөг	428	19,500	241	16,588	-187	-2,912	350	42,125	202	15,712	-148	-26,413
11	Халиун	288	13,133	234	17,698	-54	4,565	320	42,525	91	6,642	-229	-35,883
12	Хөхморьт	318	12,000	185	12,303	-133	303	230	27,125	140	9,643	-90	-17,482
13	Цогт	358	14,000	202	15,391	-156	1,391	350	31,125	181	11,525	-169	-19,600
14	Цээл	488	17,798	244	16,579	-244	-1,219	430	38,721	223	15,537	-207	-23,184
15	Чандмань	358	13,502	193	14,151	-165	649	330	30,129	193	12,984	-137	-17,145
16	Шарга	330	14,102	236	17,018	-94	2,916	320	32,625	163	9,993	-157	-22,632
17	Эрдэнэ	423	17,400	272	18,820	-151	1,420	380	37,925	373	25,917	-7	-12,008
18	Есөнбулаг	6473	179,895	2657	192,594	-3816	12,699	4,140	312,653	4,664	307,622	524	-5,031
19	Баянтоорой	208	8,600	87	7,509	-121	-1,091	200	16,025	105	6,065	-95	-9,960
20	Гуулин	258	7,200	109	6,710	-149	-490	200	17,525	108	5,438	-92	-12,087
	Нийт дүн	13,150	459,111	6,778	490,695	(6,372)	31,584	10,100	945,748	8,244	545,561	(1,856)	(400,187)

Хавсралт №3 Сонгон шалгаруулалтын тусгай шаардлагад нийцэхгүй байгаа ЭМТ-ийн жагсаалт /тусламж үйлчилгээний төрлөөр/

Шалгуур		Авбал зохих оноо	Алтай сумын ЭМТ	Баян-Уул сумын ЭМТ	Бигэр сумын ЭМТ	Бугат сумын ЭМТ	Дэлгэр сумын ЭМТ	Тайшир сумын ЭМТ	Хөхморьт сумын ЭМТ	Цогт сумын ЭМТ	Чандмань сумын ЭМТ	Баянтоорой тосгоны ЭМТ	
Ерөнхий шаардлагын оноо			30	30	30	30	30	27	30	30	30	30	
Сэргээн засах үйлчилгээний шаардлага хангасан өрөөтэй эсэх	Хөдөлгөөн засал хийх өрөө /схем зураг, Фото зураг/	Өрөөтэй бол-5 оноо, байхгүй бол-0 оноо	5	5	0	5	5	5	0	5	0	10	0
	Физик эмчилгээ хийх өрөө /схем зураг, Фото зураг/	Өрөөтэй бол-5 оноо, байхгүй бол-0 оноо	5	5	5	5	5	5	5	5	5	0	0
Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэгдсэн хүний нөөц	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /эрхийн гэрчилгээ/	Тийм бол-5 оноо, үгүй-0 оноо	5	5	5	5	5	0	5	5	5	0	0
	Мэргэжлийн үнэмлэх /45 хоног болон түүнээс дээш мэргэжил дээшлүүлсэн/	Тийм бол-5 оноо, үгүй-0 оноо	5	0	5	5	5	5	5	5	0	0	0
	Хөдөлмөрийн гэрээ, тушаал	Тийм бол-2 оноо, үгүй-0 оноо	2	0	0	0	2	0	2	0	2	0	0
Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх багаж тоног төхөөрөмж	Парафин эмчилгээний иж бүрдэл	Тийм бол-8 оноо, үгүй-0 оноо	8	8	0	0	0	0	0	8	0	0	0
	Дулаан эмчилгээ- УВЧ аппарат /хэмжих хэрэгслийн баталгаажилт/	Тийм бол-8 оноо, үгүй-0 оноо	8	0	8	8	8	8	8	8	8	6	0
	Хувьсах гүйдлийн эмчилгээ- Искра аппарат	Тийм бол-8 оноо, үгүй-0 оноо	8	0	8	8	0	8	8	8	0	8	0

	Тогтмол гүйдлийн эмчилгээ- Эмийн электрофорез	Тийм бол-8 оноо, үгүй-0 оноо	8	0	8	0	0	0	0	0	0	6	0
	Утлага эмчилгээ - Утлагын аппарат	Тийм бол-8 оноо, үгүй-0 оноо	8	8	8	8	8	8	8	8	8	7	0
	Гэрлийн эмчилгээ - Инфра улаан цацраг, лазер, солюкс	3 нь байвал-8 оноо, 2 нь байвал 6 оноо, 1 байвал-4 оноо, үгүй-0 оноо	8	4	8	8	8	8	8	8	8	3	0
Сэргээн засах үйлчилгээний дүн			70	35	55	52	46	47	49	60	36	40	0
Гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц	Стандартын дагуу сувилагчийн тоо, Сэргээн засахын мэргэжлийн үнэмлэхтэй сувилагч -1 / Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл / эрхийн гэрчилгээ/	мэргэжлийн үнэмлэхтэй 1 сувилагчтай бол 30 оноо, шаардлага хангасан сувилагчтай боловч сэргээн засалчгүй бол 20 оноо	30	30	20	0	30	30	30	30	0	30	30
Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний багц	Гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх багцын бүрдэл	Багцын бүрдэл нь бүрэн бол 40 оноо, дутуу бол 20 оноо, байхгүй бол 0 оноо	40	40	40	0	40	20	40	40	0	40	40
Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний дүн			70	70	60	0	70	50	70	70	0	70	70
Өдрийн эмчилгээ хийх шаардлага хангасан өрөө	Өдрийн эмчилгээний өрөө	Шаардлага хангасан өрөөтэй бол 30 оноо, байхгүй бол 0 оноо	30	30	0	30	30	30	30	30	30	30	30
Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /эрхийн гэрчилгээ/ Хөдөлмөрийн гэрээ, тушаал	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, хөдөлмөрийн	40	40	40	40	40	40	40	40	40	40	40

		гэрээ тушаалтай бол 40 оноо											
Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээ дүн			70	70	40	70	70	70	70	70	70	70	70
Оношилгоо, шинжилгээний өрөө	Шаардлага хангасан өрөө	Өрөөтэй бол 10 оноо, өрөөгүй бол 0 оноо	10	10		10	10	10	10	10	10	10	10
Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц	Мэргэжлийн үнэмлэх, мэргэшсэн лабораторийн эмч эсвэл лаборанттай байх, Рентген техникчтэй байх Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /эрхийн гэрчилгээ	Мэргэжлийн үнэмлэх, мэргэшсэн лабораторийн эмч эсвэл лаборанттай бол 8 оноо, үгүй бол 0	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
	Хөдөлмөрийн гэрээ, тушаал	Хөдөлмөрийн гэрээ, тушаалтай бол 2 оноо, тушаалгүй бол 0 оноо	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Хурдавчилсан оноолуур	Оноолуурын нөөц хангасан байх /5-аас доошгүй төрөл/	5-7 төрөл байвал 6 оноо /шээс, ДОХ, тэмбүү, жирэмсний сахар, В,С вирус бол 5- ыг 100 хувь гэж үзэн пропорцлоно. 5- аас доош төрөл бол 5-ийг 100% гэж үзэн пропорцын аргаар 1-5 оноо	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
Биохимийн шинжилгээ	Анализатор	Биохимийн шинжилгээний анализатортой бол 8 оноо, байхгүй бол 0 оноо	8	8	8	0	8	0	0	0	0	8	0

Эмэгтэйчүүдийн сорил /Үтрээний наац, ПАП/	Шинжилгээний иж бүрдэл	Иж бүрдэлтэй бол 6 оноо, үгүй бол 0 оноо	6	6	6	6	6	6	0	0	0	0	6
Лабораторийн шинжилгээний багаж	Шээсний анализатор	Иж бүрдэлтэй бол 6 оноо, үгүй бол 0 оноо	6	0	6	6	6	6	6	6	6	6	0
	Цусны анализатор	Иж бүрдэлтэй бол 8 оноо, үгүй бол 0 оноо	8	8	8	8	8	8	8	0	8	8	0
Багажийн шинжилгээ	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Иж бүрдэлтэй бол 6 оноо, үгүй бол 0 оноо	6	0	6	6	6	6	6	6	6	6	0
	Чанд авиан шинжилгээний аппарат	Иж бүрдэлтэй бол 7 оноо, үгүй бол 0 оноо	7	0	0	7	7	7	7	7	7	7	7
	Рентген	Иж бүрдэлтэй бол 3 оноо, үгүй бол 0 оноо	3	0	0	0	0	0	0	0	0	0	0
Оношилгоо шинжилгээний дүн			70	48	50	59	67	59	53	45	53	61	39

Хавсралт №4 ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан боловч санхүүжилтийг нэхэмжлээгүй тусламж үйлчилгээний үзүүлэлт /мян.төг/

Д/д	Эрүүл мэндийн төвийн нэр	Нэхэмжлээгүй тусламж үйлчилгээ-2021 он		Нэхэмжлээгүй тусламж үйлчилгээ-2022 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Бугат сумын ЭМТ	83	6,108	35	831
2	Бигэр сумын ЭМТ	175	40,916	7	485
3	Дарив сумын ЭМТ	15	685	9	515
4	Дэлгэр сумын ЭМТ	37	2,185	17	923
5	Жаргалан сумын ЭМТ	20	1,498	18	1,209
6	Тонхил сумын ЭМТ		-	267	39,548
7	Төгрөг сумын ЭМТ	194	48,500		-
8	Хөхморьт сумын ЭМТ	3	135	24	7,202
9	Цогт сумын ЭМТ	8	432	14	1,193
10	Цээл сумын ЭМТ	6	1	3	1,854
11	Чандмань сумын ЭМТ	15	358	2	130
12	Шарга сумын ЭМТ	22	118	9	803
13	Эрдэнэ сумын ЭМТ	15	1,052	15	1,318
14	Баянтоорой тосгоны ЭМТ	829	5,274	1017	7,507
15	Гуулин тосгоны ЭМТ	17	1,152	9	591
16	Нэгдсэн эмнэлэг	52	33,791		-
17	Энхийн зуун эмнэлэг	4	1,258		-
НИЙТ ДҮН		1712	8,439	1704	111,605.0

Хавсралт №5 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт аваагүй хасагдсан тусламж үйлчилгээний жагсаалт /Ажилтны хариуцлагатай холбоотой/ /мян.төг/

д/д	Эрүүл мэндийн төвийн нэр	Программаар шивсэн боловч баримт, нэхэмжлэл ирүүлээгүй		Хугацаа хоцорсон		Маягт дутуу хөтлөлт	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Алтай сумын ЭМТ	19	12,741		-	5	252
2	Баян-Уул сумын ЭМТ	62	1,089		-		-
3	Бигэр сумын ЭМТ		-		-	4	400
4	Бугат сумын ЭМТ		-		-	42	6,077
5	Дарив сумын ЭМТ		-		-	27	1,205
6	Дэлгэр сумын ЭМТ		-		-	15	861
7	Жаргалан сумын ЭМТ		-		-	27	1,524

8	Тайшир сумын ЭМТ		-	6	692	55	4,160
9	Тонхил сумын ЭМТ	80	2,262		-	11	540
10	Төгрөг сумын ЭМТ		-		-	14	630
11	Халиун сумын ЭМТ	4	180		-	4	318
12	Хөхморьт сумын ЭМТ	6	46		-	18	1,090
13	Цогт сумын ЭМТ	40	1,279		-	6	378
14	Цээл сумын ЭМТ	1	50		-	185	3,879
15	Чандмань сумын ЭМТ	218	8,172	3	310	10	577
16	Шарга сумын ЭМТ		-	45	325	178	2,759
17	Эрдэнэ сумын ЭМТ		-	11	41	101	1,417
18	Баянтоорой тосгоны ЭМТ	6	381		-		-
19	Гуулин тосгоны ЭМТ		-		-	16	1,127
20	Энх-Алтай ӨЭМТ		-		-	138	4,740
21	Жаргалан Алтай ӨЭМТ		-		-	258	5,631
22	Марал-Алтай ӨЭМТ		-		-	167	3,869
23	УАУНЭ		-		-	3	855
24	Оношилгоо, эмчилгээний цогц төв эмнэлэг		-	18	3,830		-
25	Эрүүл-Ирээдүй эмнэлэг		-			7	3,339
26	Энхийн зуун эмнэлэг	2	463				-
27	Нар элс сувилал					19	4,125
28	Шимт элс сувилал					3	750
НИЙТ ДҮН		438	26,662.0	83	5,197.7	1313	50,502.7

Хавсралт №6 Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин он		Хүрсэн түвшин он	
				2021	2022	2021	2022
НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ							
1.1.“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах чиглэлээр:							
1.1.1	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	96.4	97	-	98	97.8
1.1.2	Дархлаажуулалтад хамрагдсан хүн ам	хувь	0	60	-	72	50.4
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:							
2.1.1.	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	90	95%-иас доошгүй	95%-иас доошгүй	96.6	96
	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт	хувь	65.4	75	77.0	70.8	61.3
	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралт	хувь	75.5	79.4	81.4	47.6	54.7
	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралт	хувь	-	55.0	60.0	33.6	27.1
	Хорт хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийлгэсэн	хувь	-	90.0	100	86.2	99.2
	10000 хүн амд вируст гепатитын өвчлөл	түвшин	0.9	0.9	0.9	0.5	0.5
	Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	хувь	99.3	Суурь үзүүлэлтээс доошгүй		99.4	98.1
	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралт	хувь	99.8	Суурь үзүүлэлтээс доошгүй		99.8	98.5
	Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт	хувь	99.4	Суурь үзүүлэлтээс доошгүй		99.8	97.8
2.1.2	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промилль	0	0	0	0	0
	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	8.5	8.5	8.3	17.6	13.4
	Байгуулагдсан төв, нэгж, яаралтай тусламжийн цэг	тоо	0	Нэгж-2	Төв-1	2	1
2.1.3	Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт	тоо	2	5	3	7	5

	Багийн эмчийн унааны хангалт	тоо	4	39	28	39	6
	Эмчилгээ болон оношилгооны тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлсэн байгууллага	тоо	12	7	7	23	21
2.1.4	Мобайл технологи нэвтрүүлсэн сум	тоо	2	2	2	1	3
	“А” зэрэглэлийн сумын Эрүүл мэндийн төвд алсын зайн анагаах ухаан буюу телемидцинийг нэвтрүүлсэн байгууллагын тоо	тоо	0	-	1	-	0
2.1.5	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлсэн байгууллага	тоо	0	2	22	2	22
2.1.6	Цахимаар зохион байгуулах төндэрт нэмэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл	тоо	8	Ерөнхий гэрээний дагуу худалдан авах эмийн нэр төрлийг нэмэгдүүлж, нийтлэг хэрэглэдэг урвалж оношлуурыг хамруулсан байна.		20	5
2.1.7	Гадаадад сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	тоо	0	-	1	-	1
	Богино хугацааны сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	тоо	1183	1962	1962	2223	3354
	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	тоо	7	5	5	27	9
	Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох орон сууцанд орсон эрүүл мэндийн ажилтан	тоо	11	-	5	-	3
2.1.8	Шинэ барилгатай болсон эрүүл мэндийн байгууллага	тоо	2	2	-	1	0
	Өргөтгөл хийгдсэн эрүүл мэндийн байгууллага	тоо	2	-	2	1	0
	Их засвар хийгдсэн эрүүл мэндийн байгууллага	тоо	2	1	1	1	0
2.1.9	Нэмэгдүүлсэн тусламж, үйлчилгээний нэр төрөл	тоо	2	2	1	2	7
	Нэгдсэн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн байгууллага	тоо	0	1	-	1	-

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]